



“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны 05 дугаар сарын
10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 дүгээр
шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулав.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын
23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
04 дүгээр шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулав.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын
28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжсит хурлын
03 дугаар шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулав.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын
15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжсит хурлын
23/04 дугаар шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулав.

“ЛЭНДМН ББСБ” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Нийтлэг үндэслэл

- “Лэндмн ББСБ” (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн хүрээнд үйл ажиллагаага явуулах нээлттэй хувьцаат компани (цаашид “ХК” гэх) мөн.
- Компани нь гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, хамтарсан хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно.
- Компани нь өөрийн бэлгэдэл, тогтоосон журмын дагуу хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрнийхээ дараа “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- Компани нь хугацаагүйгээр үйл ажиллагаа явуулна.
- Компани нь охин буюу хараат компани байгуулж болох бөгөөд Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар буюу төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.
- Энэхүү дүрэм болон ТУЗ-аас батлах журмууд нь Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд энэхүү дүрэм болон ТУЗ-аас батлах журмаар тусгайлан зохицуулаагүй харилцааг Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид зааснаар зохицуулна.
- Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд тус хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлт нь дүрмийн хэсэг, зүйл, заалттай зөрчилдэх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх ба шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

2. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг

- Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр “Лэндмн ББСБ”ХК, Англи хэлээр “Lendmn NBFI” JSC гэнэ.
- Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34 хаягт байрлах
Сувд төв, 1 болон 2 тоот

/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр шийдвэрээр өөрчлөлт оруулав/.

Харилцах утас: 976-7707-0101

Электрон шуудан: service@lend.mn

Вэбсайт: www.lend.mn



- 3. Компанийн эрхэм зорилго**
- 3.1. Компанийн эрхэм зорилго: Дэлхийд танигдсан цахим санхүүгийн үйлчилгээг Монгол хүн бүрт
 - 3.2. Компанийн алсын хараа: Харилцагчийг дээдэлсэн, үнэ цэнэтэй үйлчилгээг түгээгч, цахим санхүүгийн чадварлаг байгууллага болох

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэл

- 4.1. Компани нь банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 4.2. Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:
 - 4.2.1. Зээл;
 - 4.2.2. Факторингийн үйлчилгээ;
 - 4.2.3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ;
 - 4.2.4. Гадаад валютын арилжаа;
 - 4.2.5. Итгэлцийн үйлчилгээ;
 - 4.2.6. Төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулинд заасан бусад төрлийн үйл ажиллагаа;
 - 4.2.7. Хуулиар хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа;

/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулав/.
 - 4.2.8. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;

/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр нэмсэн/.
 - 4.2.9. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэлт огож.

/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр нэмсэн/.

/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 23/04 дугаар шийдвэрээр хасав/.
- 4.3. Компани нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мердеж ажиллана.
- 4.4. Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжоор хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэх болон ажил гүйлгээг хийх бүрэн эрхтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэнд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 5.2. Компани нь нэг бүр нь 10 (арван) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800'000'000 (найман зуун сая) ширхэг энгийн хувьцаатай байна.
- 5.3. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.
- 5.4. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.



6. Компанийн хувьцаа эзэмшигч

- 6.1. Хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байж болно.
- 6.2. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

7. Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага

- 7.1. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.
- 7.2. Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.
- 7.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

8. Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
- 8.3. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:
 - 8.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
 - 8.3.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан;
 - 8.3.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
 - 8.3.4. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;
 - 8.3.5. аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
 - 8.3.6. компанийн тухай хууль боловон түрэмл заасан бусад тохиолдол
- 8.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:
 - 8.4.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
 - 8.4.2. нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
 - 8.4.3. нэмж гаргах хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх;
 - 8.4.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 8.4.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 8.4.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 8.4.7. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, ТУЗ-ийн гишүүн өөрөө хүссэн болон хуульд заасан бусад нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 8.4.8. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт, жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэж батлах;
 - 8.4.9. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу баталж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
 - 8.4.10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу баталж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 8.4.11. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 8.4.12. ТУЗ-өөс боловчуулсан компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэн, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэн батлах;



/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр хүчингүй болсонд тооцсон/.

- 8.4.13. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 8.4.14. Компанийн тухай хуульд заасан бусад асуудал.
- 8.5. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална. Үүнд:
- 8.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
 - 8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 8.5.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 8.5.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
 - 8.5.5. Давуу эрхийн хувьцаа гаргах;
 - 8.5.6. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 8.5.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэж;
/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр хүчингүй болсонд тооцсон/.
 - 8.5.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх эсэх;
 - 8.5.9. Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваах;
 - 8.5.10. Хууль тогтоомжид заасан бусад.
- 8.6. Энэхүү дүрэм болон хуульд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоноос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.
- 8.7. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох 9 гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж хүмүүсийн нэрсийг тус тусад нь жасана.
- 8.8. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд ТУЗ нь 9 гишүүнтэй байх тул энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг өгнө. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- 8.9. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолоохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.
- 8.10. Хуралд оролцох журам:
- 8.10.1. Хувьцаа эзэмшигч нь төлөөлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох итгээдийг бичигчээр олгосон итгэмжилэлийн үндсэн лээр оролтуулж болно.
 - 8.10.2. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшилгэсэн хуралд хүчинтэй хэвээр байна.
 - 8.10.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү дүрмийн 9.7-д зааснаар тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.
 - 8.10.4. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах хуудсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргах ба тухайн хэлэлцэх асуудалд санал ирүүлсэн хувьцаа

эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

- 8.10.5. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 8.10.6. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшууллах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 8.10.7. Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох; компанийн хэлбэрийг өөрчлөх; компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох; хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

- 8.11. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдер нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өвлияас өмнө байж болохгүй.

/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/.

- 8.12. Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох:

- 8.12.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргахдаа тогтооно.
 - 8.12.2. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэртээ тогтооно. Санал авах хуудсанд Компанийн оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл зэргийг тусгана.
 - 8.12.3. Санал авах хуудсанд (ТУЗ болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.
- 8.13. Хувьцаа эзэмшижийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг компани бүрэн хариуцна.
 - 8.14. Хувьцаа эзэмшигчлийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал лууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын шийдвэр, тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.
 - 8.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарлах болон бусад тэмдэглэлтэй холбоотой харилцааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

9. Толоолоо удирдах зөвлөл

- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөг цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хуульд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 9.2. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна.
- 9.3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил байна. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.



- 9.4. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 9.5. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу нөхөн сонгох бөгөөд тус асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 9.6. ТУЗ нь Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хамааруулснаас бусад асуудал буюу дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.6.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратегийг тодорхойлох, компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөг батлах;
 - 9.6.2. компанийн үнэт цаасыг гаргах;
 - 9.6.3. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 9.6.4. компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх, стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд арилжааны эх үүсвэр татан төвлөрүүлэх;
 - 9.6.5. гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоо;
 - 9.6.6. компанийн гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 9.6.7. компанийн хөндлөнгийн Аудитыг сонгож, гэрээ байгуулах;
 - 9.6.8. ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
 - 9.6.9. гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тогтоо;
 - 9.6.10. байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг батлах;
 - 9.6.11. компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, хөрөнгө оруулалт хийх замаар компани үүсгэн байгуулах, хууль болон нийтээр дагаж мөрдөх журамд заасан хүрээнд бусад хуулийн этгээдийн хувь эзэмшлийг худалдан авах, Компанийг төлөөлж үүсгэн байгуулагч өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг томилох, бүрэн эрхийг нь тодорхойлох;
- /Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/
- 9.6.12. компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
 - 9.6.13. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
 - 9.6.14. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн одор болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 9.6.15. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 9.6.16. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
 - 9.6.17. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмуудыг батлах;
 - 9.6.18. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 9.6.19. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 9.6.20. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 9.6.21. эрх бүхий албан тушаалтны компанийд учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 9.6.22. Компани нь энэхүү дурмийн 4.2.6 дах заалтад заасан Санхүүгийн Зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх эсэх асуудлыг бие даан шийдвэрлэх;
- /Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулав/
- 9.6.23. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал, түүнчлэн Компанийн тухай хууль, компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын эрхэд хамааруулснаас бусад буюу ТУЗ шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх.



/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 04 дүгээр шийдвэрээр өөрчлөлт оруулав/

- 9.7. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хурээнд хариуцуулан гүйцэтгүүлж болно.

/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/.

- 9.8. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн гишүүдийн саналаар нэмэлт хурал хуралдуулж болно.

- 9.9. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.

- 9.10. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

- 9.11. Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

- 9.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.

- 9.13. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

9.13.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;

9.13.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;

9.13.3. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

10. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

- 10.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхийн саналаар сонгоно.

- 10.2. Компанийн ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэнэ.

- 10.3. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль ирг гишүүп гүйцэтгэнэ.

11. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэн сонгох

- 11.1. ТУЗ нь нэр дэвшүүлэх хороотой байна.

- 11.2. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн зохих журамд заасан шалгуурыг хангасан хүнийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулж ХЭХ-д нэр дэвшүүлнэ.

12. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн

- 12.1. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо дэвшүүлнэ:

12.1.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшигдэггүй;

12.1.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

12.1.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдагтгүй;

12.1.4. компанийтай бизнесийн аливаа холбоогүй;

12.1.5. хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

- 12.2. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:

12.2.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нелөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихөөс урьдчилан сэргийлэх,



- зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хүргүүлэх;
- 12.2.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 12.2.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх эрхтэй;
- 12.2.4. компанийн нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тодруулга хийх;
- 12.2.5. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.
- 12.3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:
- 12.3.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 12.3.2. Санхүүгийн тайландауд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- 12.3.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

13. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга

- 13.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 13.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал ба ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 13.3. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулна.
- 13.4. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.
- 13.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчлийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал Болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны улдааг хангах ажлыг зохион байгуулна.
- 13.6. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.
- 13.7. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.

14. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороо

- 14.1. ТУЗ нь дэргэдээ нь эрсдэлийн удирдлагыг, аудитыг, цалин, урамшууллыг, нэр дэвшиүүлэх байнгын хороодлтой байна.
- 14.2. Аудитыг, цалин, урамшууллын, нэр дэвшиүүлэх хороодын гишүүдийн туравны хөөрөө доошгүй нь толоолон удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 14.3. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллуулж болно.
- 14.4. Эрслэлийн удирдлагын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 14.4.1. компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;
- 14.4.2. компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;
- 14.4.3. компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн түвшинд хяналт тавих.
- 14.5. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 14.5.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;



- 14.5.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- 14.5.3. аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- 14.5.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 14.5.5. компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.
- 14.6. Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 14.6.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- 14.6.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ дүрэм болох Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 14.6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд улируулан эсхүл шинээр сонгуулахаар нэр дэвшүүлэх;
- /Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/*
- 14.6.4. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 14.6.5. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- 14.6.6. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтын ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- 14.6.7. Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.
- 14.7. Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 14.7.1. компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 14.7.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулам;
- 14.7.3. компанийд мөрдож байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.
- 14.8. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

15. Гүйцэтгэх удирдлага

- 15.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлagnана.
- 15.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.



- 15.3. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.
- 15.4. ТУЗ-өөс зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
- 15.5. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаага явуулна. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, шагнал, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.
- 15.6. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэрээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллага явуулна.
- 15.7. Гүйцэтгэх захирал нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг нь хангуулах эрхтэй.
- 15.8. Гүйцэтгэх удирдлага нь Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, зохистой эрслэлийн түвшинд компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдах зохион байгуулах зарчмыг баримталж ажиллана.
- 15.9. Гүйцэтгэх удирдлага нь компанийн үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүйн орчин, энэхүү дүрэм, стратеги, бизнес төлөвлөгөө, жил бүрийн санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв болон ТУЗ-ийн шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээний хүрээнд удирдах бөгөөд сар, улирал, жилийн тайлан, шаардлагатай бусад тайланг ТУЗ, Хувьцаа эзэмшигчид болон холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлнэ.
- 15.10. Гүйцэтгэх захирал болон шаардлагатай тохиолдолд удирдлагын багийн гишүүд нь ажлаа ТУЗ-д тайлагнана.

16. Компанийн дотоод аудит

- 16.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн дотоод аудитаар дамжуулан хэрэгжүүлнэ.
- 16.2. Дотоод аудит нь компанийн үйл ажиллагаанд хяналт тавих түвшний мэргэжлийн болон ажлын туршлагатай ажилтан эсвэл ажилтнууд бүхий нэгжээс бүрдсэн байх бөгөөд ТУЗ-өөс баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллага явуулна.
- 16.3. Компанийн өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ-ийн томилсон дотоод аудит хэрэгжүүлнэ.
- 16.4. Дотоод аудит нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эркээй байна.
- 16.5. Дотоод аудитын албанаас хийш шалгалт нь ээлжит болон тусгай гэсэн хэлбэртэй байна. Ээлжит шалгалтын төлөвлөгөөт хуваарийг өмнөх жилийн 12 дугаар сард албаны дарга боловсруулан ТУЗ-оор батлуулан ажиллана. Харин ТУЗ, эсхүл Гүйцэтгэх захирлын даалгавраар тэдгээрийн баталсан удирдамжийн дагуу тодорхой асуудлаар хийх шалгалтыг тусгай шалгалт гэнэ.

17. Хөндлөнгийн аудит

- 17.1. Аудитын тухай хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй заавал гэрээ байгуулж ажиллуулна.
- 17.2. ТУЗ –ийн Аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу СЗХ-нд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.
- 17.3. Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заасан байна.
- 17.4. Дараах этгээдийг компанийн дотоод Аудитаар сонгон ажиллуулахыг хориглоно:
 - 17.4.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаалтан бол;
 - 17.4.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсвэл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг;
 - 17.4.3. Аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар компанийтай хэлцэл хийсэн этгээд бол;



- 17.5. Аудитын шалгалт нь ээлжит бус байна.
- 17.6. Компанийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
- 17.7. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсвэл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компани болон хувь эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх ба бусад тохиолдолд компани өөрөө буюу шаардлага тавьсан талууд хариуцна.

18. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан

- 18.1. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.
- 18.2. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан хамтран хариуцна.
- 18.3. ТУЗ нь компанийн санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 18.4. Компани Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлж байх үүрэгтэй.

19. Их хэмжээний хэлцэл

- 19.1. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:
 - 19.1.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;
 - 19.1.2. Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.
 - 19.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн хуралд оролцсон саналын эрхтэй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100 хувь санал нэгтэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхиин саналаар шийдвэрлэнэ.
- /Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлэжит хурлын 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/*
- 19.3. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнөө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг ТУЗ тогтооно.
 - 19.4. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлоходоо ТУЗ нь Аудитын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн /мөнгөний ханшины уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

20. Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

- 20.1. Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанийтай дор дурдсан харилцаанд орсон бол компанийтай, эсхүл түүний хараат болон охин компанийтай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:
 - 20.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
 - 20.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-иос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - 20.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн, толгойлох компанийн эрх бүхий албан



- тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцаа ногдол хувийн 20 болон түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- 20.1.4. энэ хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хүргэж байгаа.
- 20.2. Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:
- 20.2.1. тэдгээрийн гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр;
- 20.2.2. тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;
- 20.2.3. тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанийтай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүргэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд.
- 20.3. Энэ зүйлийн заалтууд дараах тохиолдолд үл хамаарна:
- 20.3.1. хувьцаа эзэмшигч нь хувьцаа худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх тохиолдол;
- 20.3.2. компани нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авахад;
- 20.3.3. Хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.
- 20.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.
- 20.5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн санаалаар гаргана.
- 20.6. Компани нь дараах тохиолдолд Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанийд сонирхлын зорчилгүй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:

/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/.

- 20.6.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 20.6.2. компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 20.6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус бүх гишүүн хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.
- 20.7. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.
- 20.8. Компани тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

21. Компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага

- 21.1. Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТҮЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Дэл захирал, Ерөнхий наягтлан бодогч, ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.
- 21.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:
- 21.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТҮЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
- 21.2.2. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгнө;
- 21.2.3. Компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
- 21.2.4. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;



- 21.2.5. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
- 21.2.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.
- 21.3. Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 21.4. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД

22. Үнэт цаас худалдах, эргүүлэн авах

- 22.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.
- 22.2. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу эргүүлэн худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

/Энэ хэсэгт “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжсүт хурлын 03 дугаар шийдвэрээр өөрчлөлт оруулсан/.

- 22.3. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно.

/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжсүт хурлын 03 дугаар шийдвэрээр хүчингүй болсонд тооцсон/.

- 22.4. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

23. Погдол ашиг хуваарилан олгох

- 23.1. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.
- 23.2. Ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашигийн дүн нь хувьцаа бүрийн хувьд адил байна.
- 23.3. Ногдол ашигийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үзүүлэлтийн колбэрээр толиж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 23.4. Түүнчлэн улсын үзүүлэлтийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.
- 23.5. Компани нь хууль тогтоомжид заасан бүх ихцэл бисэлгээний тохиолдолд энэйн хувьцаанд хамаарах ногдол ашигийг хуваарилж болно.
- 23.6. Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашигийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашиг аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.
- 23.7. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашигийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашигийг олгох үүрэгтэй.
- 23.8. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноост тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.



- 23.9. ТҮЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.
- 23.10. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүргэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.
- 23.11. ТҮЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлого батална.

24. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

- 24.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг “Компанийн тухай” хууль, энэ дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 24.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан журмаар татан буулгана.
- 24.2.1. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
 - 24.2.2. Компанийг татан буулгах талаар ТҮЗ дүгнэлт гарган хүргүүлснийг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх зөвшөөрсөн;
 - 24.2.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.

25. Дүрэм хүчин төгөлдөр болох

- 25.1. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэгдэн, батлагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 25.2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

-----oOo-----

